

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ”-Д
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2026/14-9/ШТА-НА

Чойбалсан хот 2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал, Я.Зориг, Ө.Сийлэгмаа
Аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг, Б.Одхүү, С.Энхбаатар,
Б.Оюунхэрлэн, М.Ганбилэг, Ч.Удвалноров
Утас: 7058-4207

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4

БҮЛЭГ 1. СУМАНД ТӨРИЙН САНГИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.....

5

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актуудыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна.....5-6

1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц суманд бүрдээгүй байна.....6-14

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГААС ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХ ОЛГОЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ХУГАЦААНД НЭЭГЭЭГҮЙ БАЙНА.....

14

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд хийгдээгүй байна.....14-16

2.2. Төрийн сангаас анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу гүйлгээнүүдийг буцааж ажилласан байна.....16-19

2.3. Аймгийн төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна.....19-22

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	23
ДҮГНЭЛТ:	24
ҮАГ-ЫН НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:.....	25-26
ЗӨВЛӨМЖ:	27
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	28

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СЯ	Сангийн яам
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
MNS	Mongolian national standard

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн хийлээ.</p>
Аудитын зорилт	<p>Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх; • Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	<p>Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, Дорнод аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, 14 сумын санхүүгийн албаны 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд аудитыг хийж гүйцэтгэсэн.</p>
Аудитын арга шалгуур үзүүлэлт зүй,	<p>Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” болон МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.</p>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	<p>Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер Д.Нармандах аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, Я.Зориг, Ө.Сийлэгмаа аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг, Б.Одхүү, С.Энхбаатар, Б.Оюунхэрлэн, М.Ганбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын төлөвлөгөөг 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 5 дугаар сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 29-ний өдрийн хооронд гүйцэтгэж тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт тус тус хүргүүлээ.</p>

БҮЛЭГ 1. СУМАНД ТӨРИЙН САНГИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актуудыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна.

1.1.2. Орон нутгийн холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зарим тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцээгүй байна.

1. Аймгийн ОНХС-ийн гүйлгээн дээр Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга 1-р гарын үсэг, Хэрлэн сумын ОНХС-ийн гүйлгээн дээр Хэрлэн сумын Санхүүгийн албаны дарга 2-р гарын үсэг зурж байна. Энэ нь төрийн сангийн байгууллага өөрөө санхүүжилтийн шийдвэрт оролцож, өөрийн шийдвэрээ өөрөө хянаж буй хэлбэртэй байна. Бусад сумдад ОНХС-ийн гүйлгээн дээр сумын ЗДТГ-ын нягтлан бодогч зурж байна.

Чиг үүргийн давхардал, дотоод хяналт сулрах, өөрийн шийдвэрээ өөрөө хянах нөхцөл, санхүүгийн сахилга, хариуцлагын эрсдэл, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Мөн Төсвийн тухай хууль, Төрийн сангийн чиг үүргийн зохицуулалт, дотоод хяналтын зарчмуудтай нийцэхгүй байна.

Төрийн сангийн чиг үүрэг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1. төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих” гэж заасан нь төрийн сан “зарцуулалт хийх субъект” биш, харин “хяналт тавих субъект” гэж тодорхойлогдсон байна.

Аймгийн Засаг даргад аймгийн ОНХС-гийн зарцуулах эрхийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж ...;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах **зөвлөмж өгөв**.

ҮАГ-ын нэгдсэн тайланд: Сумын санхүүгийн албаны дарга ОНХС-гийн гүйлгээн дээр гарын үсэг зурахгүй байх талаар холбогдох журамд тусгуулах санал хүргүүлэв.

2. Сумын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нар нь ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй үед нэг нэгийгээ түр орлон ажиллах шаардлага гардаг байна.

Энэ үед харилцан бие биеэ орлон төрийн сангийн гүйлгээг хийж, хянаж, баталгаажуулан ажиллаж байгаа нь гүйлгээ хийх, хянах чиг үүргийн салангид байдлыг алдагдуулж, дотоод хяналтын үр нөлөөг бууруулах, Төсвийн тухай хууль болон төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зорилго, зарчимтай нийцэхгүй нөхцөл үүсгэж байна.

Нэг мэргэжилтэн гүйлгээ үүсгээд, өөрөө шалгаад, өөрөө батлаад байвал дотоод хяналт бодитоор байхгүй. Ийм нөхцөлд хуурамч гүйлгээ гарах, санхүүгийн сахилга алдагдах эрсдэлтэй үр дагаврыг үүсгэж байна.

Сангийн сайдын 2024 оны 256 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар"-ын 6.9-д “Энэ зааврын 3 дугаар зүйлд заасан эрхүүдийг нэг албан тушаалтанд давхардуулан

олгохгүй бөгөөд өөрт оногдсон эрхээс өөр эрхээр системд нэвтэрч ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

ҮАГ-ын нэгдсэн тайланд: Сумдын төрийн сангийн дотоод хяналтыг хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах санал тусгуулахаар хүргүүлэв.

1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц сумдад бүрдээгүй байна.

1.2.1 Аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тоо ялгаатай байгаа нь улсын хэмжээнд мөрдөх нэгдсэн бүтэц, орон тооны жишиг норматив баталж гаргаагүйтэй холбоотой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Сангийн яамыг 10 газартай байхаар баталж, үүнээс Төрийн сангийн газар нь Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс, Төлбөр тооцооны хэлтэстэй байхаар батлагджээ.


Дүрслэл №1. “Төрийн сангийн газрын дотоод бүтцийн схем”



Эх сурвалж: “МУ-ын ЗГ-ын 2025 оны 07 дугаар тогтоол”

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д “Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.” гэж заасан.

Дүрслэл №2. “Төрийн сангийн үйл ажиллагааны өнөөгийн бүтэц”



Эх сурвалж: www.legalinfo.mn, www.mof.gov.mn

1. Төсвийн тухай хуулийн 36.3-т дараах зохицуулалтыг тусгасан.

“Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нээгдсэн алба байгуулж болно.”

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 326 дугаар “Санхүүгийн алба байгуулах тухай” тогтоолоор сумын санхүүгийн албыг байгуулж, орон тооны жишиг нормативыг 2 орон тоотой байхаар баталсан байна.

Дорнод аймгийн хувьд 14 сумтай, сум бүрд Санхүүгийн албыг дарга болон Төрийн сангийн төлөөлөгч (мэргэжилтэн) гэсэн 2 орон тоотой байхаар зохион байгуулсан байна. 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр Булган, Сэргэлэн, Баянтүмэн зэрэг 3 суманд хүний нөөцийн хүрэлцээгүй байдлын улмаас тус бүр 1 орон тоо дутуу, бусад 11 сумын хувьд орон тоо бүрэн ажилласан байна.








2. Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны А/141 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтцийг баталсан байна.

Тус захирамжаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтцийг нийт 9 орон тоотой байхаар баталж, 2025 оны жилийн эцсийн байдлаар тухайн албан тушаалуудад хүний нөөц 100 хувь хангагдан ажиллажээ.

Бүтэц, орон тооны зохион байгуулалтаас харахад удирдах албан тушаалтан 1, ерөнхий нягтлан 1, ахлах мэргэжилтэн 3, улсын байцаагч 1, мэргэжилтэн 3 байна.

Төсвийн байгууллага хариуцсан мэргэжилтэн 3 байгаа нь аймгийн хэмжээнд 250 гаруй төсөвт байгууллага, түүний өдөр тутмын гүйлгээг хийж байгаатай холбоотой байна.

Дүрслэл №3. “СТСХ-ийн батлагдсан орон тоо”

Албан тушаал	Орон тоо
 Хэлтсийн дарга	1
 Аймгийн Ерөнхий нягтлан бодогч	1
 Хэлтсийн ахлах мэргэжилтэн, төсвийн зарлага хариуцсан	1
 Хэлтсийн ахлах мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан	1
 Бүртгэл хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч	1
 Төсвийн орлого хариуцсан ахлах мэргэжилтэн	1
 Төсвийн байгууллага хариуцсан мэргэжилтэн	3

Эх сурвалж: “Аймгийн ЗД-ын 2025 оны А/141 дүгээр тушаалын 2-р хавсралт”

Улсын хэмжээнд бүтэц, орон тооны батлагдсан стандарт, норм норматив байхгүй байгаа тул СТСХ-ийн энэ бүтцийг оновчтой зохион байгуулагдсан эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Дорнод аймгийн СТСХ-ийн бүтэц, орон тоог бусад аймгуудтай харьцуулсан судалгааны үр дүнг авч үзье.

Дүрслэл №4. “Аймгуудын СТСХ-ийн бүтэц, орон тооны харьцуулсан үзүүлэлт”

Үзүүлэлт	Орон тоо	Хүн амын тоо	Сумын тоо	Бүртгэлтэй ААНБ-ын тоо	Идэвхтэй ААНБ-ын тоо
Дорнод	9	84,991	14	2.5-3.0 мянга	1.0-1.3 мянга
Хэнтий	7	79,939	18	2.3-2.8 мянга	0.9-1.2 мянга
Орхон	8	111,492	2	6.0-7.5 мянга	3.0-3.8 мянга
Говь-Алтай	7	56,831	18	1.5-2.0 мянга	0.6-0.9 мянга

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (www.1212.mn), нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (www.data.mn) болон Хэнтий, Орхон, Говь-Алтай, Дорнод аймгуудын ЗДТГ-ын албан ёсны цахим хуудас

Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, албан хаагчдын тоо харилцан адилгүй байгаа бөгөөд үүнд тухайн орон нутгийн хүн амын тоо, сумдын газар зүйн байршил, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- **Чиг үүргийн төрөлжилт өндөртэй загвар:** Орхон аймаг зэрэг хүн ам, эдийн засгийн төвлөрөл ихтэй орон нутагт СТСХ-ийн бүтэц, орон тооны чиг үүргийн төрөлжилт илүү хөгжсөн бөгөөд төрийн үйлчилгээний суваг, нэр төрөл нэмэгдсэн бүтэцтэй байна.
- **Нийтлэг буюу хосолсон загвар:** Хэнтий болон Говь-Алтай аймгуудын зохион байгуулалт нь Дорнод аймагтай ижил төстэй бөгөөд орон нутгийн төсөв болон төрийн сангийн үйл ажиллагааг нэг удирдлага дор нэгтгэн зохион байгуулдаг нийтлэг шинж чанартай байна.

Аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тоо ялгаатай байгаа нь улсын хэмжээнд мөрдөх нэгдсэн бүтэц, орон тооны жишиг норматив байхгүйтэй шууд холбоотой байна.

ҮАГ-ын нэгдсэн тайланд: аймгуудын хүн амын тоо, засаг захиргааны нэгж (сум)-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл болон төсвийн цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр "Аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тооны жишиг норматив"-ыг шинээр боловсруулан баталж, улсын хэмжээнд нэгдсэн байдлаар мөрдүүлэх санал тусгуулахаар хүргүүлэв.

1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй ч, албан тушаалын тодорхойлолт нь орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавартай бүрэн нийцэхгүй байна.

Дорнод аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь батлагдсан бүтэц, орон тооны дагуу нийт 7 албан тушаалын тодорхойлолтын дагуу 9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүрслэл 5. Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц



Эх сурвалж: Нэгдсэн судалгаа, 2026 он

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Төрийн сангийн чиг үүрэгтэй уялдсан бөгөөд аудитаар Албан тушаалын тодорхойлолт¹-д бүрэн туссан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын АТТ-ыг Сангийн сайдын 90 дүгээр тушаалаар батлагдсан жишиг заавартай тулган баталгаажуулалт хийсэн байдал

№	АТТ-ын нэр	СС-ын 90 дүгээр тушаал	Илрүүлэлт
1	Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн (даргаа орлодог)	1.2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийн зарлагын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж, төсвийн хөрөнгө оруулалтын журмын дагуу хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт, хяналтын хүснэгтийг үндэслэн бүртгэл, тайлагналыг хариуцах. /ОНХСан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, техник хяналт, мал хамгаалах сан гм.../ 1.2.18. Бүртгэлийн мэргэжилтэнг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох	1.2.4 дэх заалт АТТ-д бүрэн тусгагдаагүй 1.2.18 дахь заалт АТТ-д тусгагдаагүй
2	Бүртгэл хариуцсан мэргэжилтэн (Улсын байцаагч)	1.3.12. Ерөнхий нягтлан бодогч болон дотоод хяналтын мэргэжилтнийг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох	АТТ-д тусгагдаагүй

¹ Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "албан тушаалын тодорхойлолт" гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

3	Төсвийн зарлага/орлого хариуцсан ахлах мэргэжилтэн	1.4.20. Хэлтсийн даргыг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох	АТТ-д тусгагдаагүй
4	Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн (даргаа орлодог)	1.5.9. Хэлтсийн архивын бүртгэл хөтлөлтийг хийж аймгийн архив хариуцсан хэлтэс, тасагт хүлээлгэн өгөх 1.5.16. Төсвийн мэргэжилтэнг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох	АТТ-д тусгагдаагүй
5	Төсвийн байгууллага хариуцсан мэргэжилтэн	1.6.8. Төлбөр тооцооны мэргэжилтэнг ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлох	АТТ-д тусгагдаагүй

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын АТТ, 2025 он

Мөн нийтлэг байдлаар тухайн хэлтсийн албан тушаалын тодорхойлолтод мэргэшлийн шаардлагын талбар хэсгийг хоосон үлдээж баталсан байна.

Сэргэлэн, Булган сумдад Төсөв, төрийн сангийн мэргэжилтний орон тоо дутуу байгаа бөгөөд санхүү албаны дарга нь хавсран гүйцэтгэж байна. Мөн Баянтүмэн суманд Санхүү албаны даргын орон тоо сул байгаад төсөв, төрийн сангийн мэргэжилтэн хавсран ажиллаж байна. Харин бусад 11 суманд батлагдсан орон тооны дагуу бүрэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Халхгол, Чулуунхороот, Дашбалбар, Чойбалсан зэрэг сумд нь 2019 оноос хойш АТТ-ыг шинэчлээгүй байна. Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 208 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолын 1 дүгээр хэсэгт “..., Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралт ёсоор шинэчлэн батлахыг сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.”, 2 дугаар хэсэгт “Сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв төрийн сангийн мэргэжилтний албан тушаалыг тодорхойлолтыг 3 дугаар, ... шинэчлэн батлахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Сумын санхүүгийн албаны албан хаагчдын АТТ-ыг аймгийн СТСХ-ээс санал аваагүй баталсан байна.

Сангийн сайдын “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-т тусгагдсан Сумдын санхүүгийн албаны ажил үүргийн жишиг зааварт аймгийн 14 сумын санхүүгийн албаны дарга буюу аймгийн ерөнхий нягтлан бодогч болон төсөв, төрийн сангийн мэргэжилтний тодорхойлолтууд бүрэн нийцэж байна.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 208 дугаар тогтоолын дагуу АТТ-ыг шинэчлээгүй сумдын дээрх төсөв, төрийн сангийн мэргэжилтний АТТ-д “Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах” гэсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдах заалтыг тусгаж өгөөгүй байна.

Мөн сумдад нийтлэг байдлаар аль албан тушаалтан нь “ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд орлож ажиллах” чиг үүргийг АТТ-д огт тусгаж өгөөгүй байна.

Аймгийн төрийн сангийн мэргэжилтнүүдийн АТТ-г жишиг загварт бүрэн нийцүүлэх, Халхгол, Чулуунхороот, Дашбалбар, Чойбалсан сумдыг ТАЗ-ийн тогтоолд нийцүүлж АТТ-ыг боловсруулан баталж ажиллах **зөвлөмж өгөв**.

Дорнод аймгийн Засаг даргын А/34 дүгээр захирамжаар аймгийн төсөв батлах тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, 4 дүгээр хавсралтаар баталсан аймгийн автозамын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх эрхийг ЗДТГ-ын даргад шилжүүлсэн байна. Энэхүү эрх шилжүүлсэн захирамж нь аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн эрхийг ЗДТГ-ын нягтлан бодогчид шилжүүлэх үндэслэл болохгүй.

ТЭЗ-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2-р гарын үсгийг ТШЗ-ийн нягтлан бодогч гүйцэтгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 “... төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 19-р зүйлийн 19.2-т "Энэ хуулийн 14.1.3, 14.1.7, 14.1.11, 14.1.14, 14.1.15, 14.1.19-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна" Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ийн 3.1.2-т Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн Засаг дарга санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилно" 4.1-т "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч дор дурдсан үүрэг хүлээнэ:" гэсний 4.1.5-д "Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлбөрийн хүсэлт гүйлгээн дээр аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч 2-р гарын үсэг зурж ажиллах **зөвлөмж өгөв**.

1.2.3. Төсвийн төлөвлөлтийн Fiscal программ нь төсвийг үр дүнтэй төлөвлөх хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

Аудитаар төрийн сангийн үйл ажиллагааг хариуцсан хэлтэс, албан хаагчдыг нэгдсэн судалгаа авч үзэхэд төрийн сангийн удирдлагын цахим систем болон төрийн албаны цалингийн нэгдсэн системийн ашиглалт, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахад интернэтийн хүртээмж, программыг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системд нэг хэрэглэгчийн эрхээр зэрэгцэн хэдэн ч хүн нэвтрэх боломжтой байна. Энэ нь хэрэглэгчийн нэвтрэлтийн хяналт сул, сэжигтэй хандалтыг ялган таних механизм хангалтгүй, давхар баталгаажуулалт

хийгдэхгүй байгааг харуулж байна. Ийм нөхцөл байдал нь зөвшөөрөлгүй хандалт үүсэх, эрхийн зөрчил гарах, мэдээллийн нууцлал болон бүрэн бүтэн байдал алдагдах эрсдэлтэй байна.

Аудитын явцад төрийн сангийн албан хаагчдаас авсан нэгдсэн судалгаанд “Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?” гэсэн асуултад оролцогчдын 82.8 хувь нь интернэтийн саатлыг хамгийн түгээмэл хүндрэл гэж хариулсан байна.

Энэ үзүүлэлт нь ялангуяа сумын түвшинд цахим системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах сүлжээний дэд бүтэц хангалтгүй байгааг илтгэж, цахим системийн бодит ашиглалт техникийн орчноос өндөр хамааралтай хэвээр байгааг нотолж байна.

Дүрслэл 6. Цахим систем ашиглахад гардаг хүндрэл бэрхшээл



Иймээс судалгааны 82.8 хувийн хариулт нь зөвхөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн асуудал бус, төрийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааны тасралтгүй байдал, мэдээлэл дамжуулах хурд, тайлан мэдээ боловсруулах хууль журмын хугацаанд шууд нөлөөлөх системийн шинжтэй эрсдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

- Нэг эрхээр олон байршлаас зэрэг нэвтрэх боломж нь хэрэглэгчийн бүртгэлийн хяналтыг сулруулж, зөвшөөрөлгүй ашиглалт илрэхгүй өнгөрөх эрсдэлийг нэмэгдүүлнэ.
- Интернэтийн саатал өндөр хувьтай байгаа нь сумдын түвшинд гүйлгээ, мэдээлэл шивэлт, тайлан баталгаажуулалт, цалингийн боловсруулалтыг саатуулж, ажлын бүтээмж буурах нөхцөл бүрдүүлнэ.

Сумын төрийн сангийн интернэтийн хурд, тогтвортой байдлыг үнэлж, шаардлагатай сумдад сүлжээний хүчин чадал, нөөц холболтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах **зөвлөмж өгөв**.

Төрийн албаны цалингийн нэгдсэн систем **Payrol** программд үндсэн цалинг Засгийн газрын тогтоосон цалингийн доод хэмжээгээр автоматаар



татаж байгаа бөгөөд Засгийн газрын харьяа агентлагийн шийдвэрээр нэмэгдүүлсэн үндсэн цалинг системд тусган оруулах боломжгүй байна. Үүний улмаас цалингийн зөрүүг олгохын тулд тухайн албан хаагчийг ангилалгүй бүлэгт түр оруулж, үндсэн цалинг гараар оруулан бодолт хийсний дараа хүний нөөцийн систем дэх мэдээллийг буцаан засварлаж, хуучин ангилалд нь сэргээх замаар давхар ажил гүйцэтгэж байна.

Энэ нь цалин бодолтын процесс ажиллагааг хүндрүүлэх, хугацаа алдуулах, мэдээллийн зөрүү үүсгэх, гар ажиллагаанаас шалтгаалсан алдаа гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд **Payrol** цалингийн программд эрх бүхий байгууллагын шийдвэрээр нэмэгдүүлсэн үндсэн цалингийн хэмжээг ангилал, бүлэгтэй уялдуулан системд тусгах боломжийг бүрдүүлэх тохиргоо, хөгжүүлэлтийг хийх шаардлагатай байна.

Төсвийн төлөвлөлтийн **Fiscal программ** нь 1997 оноос хойш ашиглагдаж байгаа боловч энэ хугацаанд зөвхөн хэсэгчилсэн шинэчлэл хийгдэж, системийн үндсэн ажиллагаанд сайжруулалт хийгдээгүй байна. Үүний улмаас төсөвт байгууллагуудын төсвийн мэдээллийг төрийн сангийн мэргэжилтэн гараар шивж оруулах ажиллагаа үргэлжилсээр байгаа бөгөөд программ нь механик, гар ажиллагаа ихтэй офлайн хэлбэрээр ашиглагдаж байна. Ийм нөхцөл байдал нь төсөв төлөвлөлтийн үйл явцад ихээхэн цаг хугацаа шаардах, мэдээлэл шивэх болон нэгтгэх явцад алдаа, зөрүү гарах эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар ажлыг хөнгөвчлөх, төлөвлөлтийн үр ашиг, шуурхай байдлыг дэмжих үндсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгааг харуулж төсөв төлөвлөлтийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Төсвийн төсөл шивж оруулдаг **Fiscal.b8** программ нь аймгийн хэмжээнд нэг нэвтрэх эрхтэйгээр ашиглагдаж байгаа тул сум болон төсөвт байгууллагуудаас төсвийн төслийн мэдээллийг Excel файлаар хүлээн авч нэгтгэн, төрийн сангийн мэргэжилтэн гараар шивж оруулдаг хэвээр байна. Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төслийг бэлтгэх процесс нь Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж, маягтын дагуу аймгийн хэмжээнд нэг бүрчлэн боловсруулагдаж байгаа боловч уг ажиллагаа нь систем хооронд шууд өгөгдөл солилцох, шат шатны хэрэглэгч өөрийн мэдээллийг цахимаар оруулах боломжгүй, механик ажиллагаа ихтэй офлайн орчинд явагдаж байна. Энэ нь төсвийн төслийн үйл явцад ихээхэн цаг хугацаа шаардах, хүний оролцооноос хамаарах хамаарал өндөрсөх, мэдээлэл нэгтгэх болон шивэх явцад алдаа, зөрүү гарах эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар программ нь ажил хөнгөвчлөх үндсэн чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлж байгааг харуулж байна.

САНГИЙН ЯАМ
ТӨСВИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗАР

Fiscal.B8

Нэвтрэх нэр

Нууц үг

Төсвийн жил : 2026

2026

НЭВТРЭХ

Иймээс Fiscal программын өнөөгийн байдал нь төрийн санхүүгийн удирдлагын шинэчлэлийн зорилттой харьцуулахад хоцрогдолтой, шинэчлэл зайлшгүй шаардлагатай түвшинд байна.

Төсвийн төсөл, төлөвлөлт, батлагдсан төсөв оруулдаг **Fiscal.b8** болон холбогдох программуудыг үе шаттай шинэчлэн сайжруулах шаардлагатай байна. Үүнд сум, төсөвт байгууллага бүр өөрийн нэвтрэх эрхтэйгээр төсвийн төслөө системд шууд шивж оруулах, мэдээллийг шат дамжлагагүй нэгтгэх, Excel маягтаас хамаарах гар ажиллагааг бууруулах, төлөвлөлт болон батлагдсан төсвийн мэдээллийг нэг цонхоор удирдах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шатлал бүрээр тодорхой болгож, Сангийн яамны удирдамж, маягтын шаардлагыг системд автомат хяналттайгаар тусган, мэдээллийн үнэн зөв байдал, цаг хугацааны шуурхай байдлыг сайжруулах хөгжүүлэлтийг хийх нь зүйтэй байна.

ҮАГ-ын нэгдсэн тайланд: 1. Payrol цалингийн системд сайжруулалт хийж эрх бүхий байгууллагын шийдвэрийг оруулан тухайн дүнгээр үндсэн цалинг татдаг болгох; 2. Fiscal, Fiscal.b8 программуудад шинэчлэл хийж төсвийн байгууллагууд төсвийн мэдээллээ оруулдаг болох, төрийн сангаас түүнийг нь нэгтгэж татдаг болгож сайжруулах санал тусгуулахаар хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГААС ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХ ОЛГОЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ХУГАЦААНД НЭЭГЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт нь төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд хийгдээгүй байна.

2.1.1. Төрийн сан нь төсвийн байгууллагын төсвийн санхүүжилтийн эрхийг батлагдсан хуваарийн дагуу нээхдээ төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан холбогдох баримт шийдвэргүй шууд нээсэн байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5-д улсын төсвийн санхүүжилтийн эрх олгох, хуваарилах журам, 2.6-д орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журамд:

- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардал, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр, байр ашиглалтын үйлчилгээ, харуул, хамгаалалтын зардал, холбооны суваг ашигласны хөлс, тээврийн үйлчилгээ, халамжийн санхүүжилт, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг гэсэн зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор;
- ✓ Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, татаас санхүүжилт, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, бусад зориулалт бүхий зардлын санхүүжилтийг төсвийн байгууллагаас ирүүлсэн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт, холбогдох шийдвэр, баримт бичиг (гэрээ, гэрээг дүгнэсэн акт, ажлын

тайлан, үр дүн, зохих тооцоолол)-ийг үндэслэж ажлын 2 өдрийн дотор; олгоно гэж заасан байна.

Төрийн сан нь төсвийн байгууллагын төсвийн санхүүжилтийн эрхийг батлагдсан хуваарийн дагуу нээхдээ төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.4.10-2.4.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийн эрхийг тус журамд заасан хүсэлт болон холбогдох баримт шийдвэргүй шууд нээж ажилласан байна.

Энэ нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.5.6-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 2.4.10-2.4.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг мөн журмын 25 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэж, холбогдох шийдвэр, баримт бичиг (гэрээ, гэрээг дүгнэсэн акт, ажлын тайлан, үр дүн, зохих тооцоолол)-ийг төсвийн захирагчаар баталгаажуулан төв төрийн санд ирүүлнэ”, 2.6.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.4.10-2.4.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг мөн журмын 2.5.6-д заасантай адилаар санхүүжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Журмын дагуу санхүүжилтийн эрхийг нээж ажиллах **зөвлөмж өгөв**.

2.1.2. Улсын 2025 оны төсвийн орлого тасарсантай холбоотой төсвийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Сангийн яамнаас зардлуудыг хязгаарласны улмаас 4,107.2 сая төгрөгийн санхүүжилт Дорнод аймагт дутуу олгогдсон байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.7-д төсвийн зарцуулалтын эрх олгох журам, 2.8.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох журмыг тусгасан байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын **2.7.1-д** "... улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг **тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор** олгоно" гэж заасан.

Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг олгоогүйгээс шалтгаалж эрх сар бүрийн 5 өдрийн дотор нээгдээгүй байна. Мөн бодит байдал дээр орон нутгийн орлогын бүрдэлттэй уялдуулан зарим саруудад санхүүжилтийг журамд заасан хугацаанд олгох боломжгүй нөхцөл үүсдэг байна.

ҮАГ-т нэгдсэн тайланд: Орон нутгийн төсвийг хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно гэсэн заалтыг өөрчлөх санал тусгуулахаар хүргүүлэв.

Журмын **2.5.6, 2.6.3-д** журмын 2.4.10–2.4.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийн эрхийг нээхдээ **холбогдох хүсэлт, шийдвэр, баримт бичгийг хавсаргаж ирүүлэхийг** шаардсан.

Хүснэгт 2. “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт”

Байгууллага / Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
Жилийн батлагдсан төсөв, санхүүжилтийн эрх (сая ₮)	35,056.5	37,319.3	42,449.5
Олгосон санхүүжилт (сая ₮)	35,056.5	37,165.6	38,342.3

Байгууллага / Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
Бодит зөрүү — Батлагдсан дүн хэрэгжээгүй (сая ₮)	0 ✓	153.7	4,107.2 Δ

Эх сурвалж: “Орон нутгийн төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалт 2023-2025 он, маягт ЗЭБ№01”

Улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн 2023-2025 оны хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгох ёстой боловч хугацаа хэтрүүлэн олгож байна.

Улсын төсвийн орлого 2025 онд тасарсантай холбоотой төсвийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Сангийн яамнаас зардлуудыг хязгаарласны улмаас **4,107.2 сая төгрөгийн** санхүүжилт дутуу олгогдсон байна. Жилийн эцэст хөрөнгө оруулалтын зардлыг гэрээний дагуу шилжүүлснээс үлдсэн санхүүжилтийн үлдэгдэл 153.7 сая төгрөг байна.

Энэ нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.7.1-т “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан улсын төсвийн болон Засаг даргын баталсан орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно”, 2.7.4-т “Төв төрийн сан нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын зарцуулалтын эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төлөвлөлтийн программд хянаж оруулсан байгууллага тус бүрийн төсвийн хуваарийн задаргааны дагуу төрийн сангийн холбогдох системээр ажлын 3 өдрийн дотор олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Төрийн сангаас анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу гүйлгээнүүдийг буцааж ажилласан байна.

2.2.2. Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу гүйлгээнүүд нь нийт буцсан гүйлгээний 85.5 хувийг эзэлж байгаа бол Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болж буцсан 339.0 сая төгрөгийн 39 гүйлгээ байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан төлөвлөгөөний дагуу 2023-2025 онуудад аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын санхүүгийн албадын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Харин Дорнод аймгийн Төрийн сангийн үйл ажиллагаанд тайлант онуудад хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

Дорнод аймгийн Төрийн сангийн гүйлгээнээс 2024, 2025 онуудад нийт 10,921.8 сая төгрөгийн 1179 гүйлгээ амжилтгүй болон буцаасан төлөвт байна. Үүнээс 2024 онд 2,908.4 сая төгрөгийн 149 гүйлгээ амжилтгүй болсон бол 3,811.3 сая төгрөгийн 441 гүйлгээг буцаасан байна. 2025 онд 2,076.5 сая төгрөгийн 244 гүйлгээ амжилтгүй болсон бол 2,125.6 сая төгрөгийн 345 гүйлгээг буцаасан байна.

Хэрлэн сумын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2023-2025 оны гүйлгээнүүдээс түүвэрлэн баримтын бүрдэл бүрэн эсэх гүйлгээ зориулалт, ангиллын дагуу эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд томилолтын удирдамж байхгүй 1, сургууль цэцэрлэгүүд хүнсний материалын худалдан авалтын гэрээ байхгүй 2, оны эцэст зардлын ангилал зөрчсөн 3, гүйлгээний хавсралт дутуу 4 зэрэг зөрчлүүд илэрсэн.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.5-д “Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан хаагч, байгууллагын нэр, бүртгэлийн дансны нэр, тамга, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд тухайн шийдвэр гарсан өдөр харьяа төрийн санд энэ тухай албан бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүйгээс гарах үр дагаврыг мэдэгдэх үүрэгтэй этгээд хариуцна” гэсэн заалтын дагуу 2023-2025 онуудад 1 болон 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий 90 албан хаагчийн гарын үсгийн баталгааг шинэчилсэн байна.

Хүснэгт 3. Дорнод аймгийн Төрийн сангийн амжилтгүй болон буцаасан гүйлгээ. /сая төгрөгөөр/

№	Амжилтгүй болон буцаасан гүйлгээ	2024 он		2025 он		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Бэлтгэн нийлүүлэгчийн дансны дугаар бүртгэлгүй			22	525.7	
2	Төсвийн багц хүрэлцэхгүй	149	2,908.4	222	1,550.7	
3	Буцаасан гүйлгээний ангилал	Төсөв хүрэлцэхгүй /Төлбөр гүйцэтгэх эх үүсвэр хүрэлцэхгүй	12	41.2	6	128.4
		Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй	277	1,604.7	140	950.2
		Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу	119	1,752.7	125	767.4
		Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон	30	306.5	47	84.8
		Төлбөрийн хүсэлтийн мөнгөн дүн, үндэслэх анхан шатны баримтын дүнгээс их	2	97,5	8	7.4
		Төрийн сан, төсвийн байгууллагын харилцааг зохицуулсан журмыг зөрчсөн	1	8.7	19	187.3
НИЙТ		590	6,719.7	589	4,201.9	

Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болж буцсан 391.3 сая төгрөгийн 77 гүйлгээнээс 52.3 сая төгрөгийн 38 гүйлгээ нь системийн алдаанаас болж буцсан байна.

Төсвийн байгууллага хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн 1.1-д заасны дагуу "Санхүү, төсвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актын талаар төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх" гэснийг хэрэгжүүлж, буцаалтын гүйлгээг бууруулах ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Дорнод аймгийн Төрийн санд “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төлбөр тооцоог ажлын 3 хоногт багтаан гүйлгээг батлах **зөвлөмж өгөв**.

2.2.3. Тайлант онуудад 1,511.1 сая төгрөгийн гүйлгээг залруулснаас 38.9 сая төгрөгийн 2 гүйлгээнд холбогдох байгууллагын шийдвэр, төлбөр хийх хүсэлт зэргийг хавсаргаагүй байна.

Дорнод аймгийн Төрийн сан болон сумдын төрийн сангийн орлогын данснаас 2024 онд 83 удаагийн 293.6 сая төгрөгийн гүйлгээг, 2025 онд 67 удаагийн удаагийн 1,067.5 сая төгрөгийн гүйлгээг тус тус залруулсан байна.

Хүснэгт 4. Залруулсан гүйлгээний мэдээлэл /сая төгрөгөөр/

№	Буцаасан гүйлгээний ангилал	2024 он		2025 он	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод аймгийн Төрийн сан	19	19.9	13	42.0
2	Хэрлэн сумын Төрийн сан	44	33.2	52	57.0
3	Баян-Уул сумын төрийн сан	2	0.02	-	-
4	Сэргэлэн сумын Төрийн сан	1	1.2	-	-
5	Дашбалбар сумын Төрийн сан	-	-	1	968.3
6	Цагаан-Овоо сумын Төрийн сан	9	205.5	1	0.2
7	Халхгол сумын Төрийн сан	5	31.6	-	-
8	Хөлөнбуйр сумын Төрийн сан	1	1.1	-	-
9	Чойбалсан сумын Төрийн сан	1	0.2	-	-
10	Чулуунхороот сумын Төрийн сан	1	0.7	-	-
	НИЙТ	83	293.6	67	1,067.5

Хэрлэн сумын Төрийн сангийн 100071400914 тоот данснаас 100071455405 тоот дансанд шилжүүлсэн 2025 оны 11 сарын 14-ний өдрийн 3.9 сая төгрөгийн гүйлгээнд холбогдох байгууллагын шийдвэр, төлбөр хийх хүсэлт зэргийг хавсаргаагүй байна.

“Чандмань Тал ХХК” нь Төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт болох 3.5 сая төгрөгийг андуурч 35.0 сая төгрөгөөр шилжүүлснийг Дорнод аймгийн Төрийн сангийн 100070000952 тоот данснаас залруулж тус байгууллагын Худалдаа хөгжлийн банкны 401008834 тоот данс руу буцаан шилжүүлэхдээ;

- Холбогдох байгууллагын шийдвэр, төлбөр хийх хүсэлт зэргийг хавсаргаагүй.
- Андуурч, илүү шилжүүлсэн 31.5 сая төгрөгийг залруулах байсныг нийт 35.0 сая төгрөгөөр буцаасан.

Энэ нь "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-т “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана”, 3.4.21-т “Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн

хамт хавсаргаж ажлын 3 өдрийн дотор төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана”, 3.5.4-т “Төрийн сан бүртгэлийн дансны төлбөрийн залруулгыг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтыг үйлдэн гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу гүйлгээг залруулж ажиллах **ЗӨВЛӨМЖ ӨГӨВ.**

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнасан байна.

Аймаг сумын төрийн сангаар төлбөр тооцоо хийгддэг байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансны сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд авч баталгаажуулсан байна.

Сумдын төрийн сан нь сумын ТТЗ-ын хүрээний байгууллагуудын жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим программаар хүлээн авч нэгтгэн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэн дүгнэлт гаргуулж, аймгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд хуулийн хугацаанд нэгтгүүлсэн байна.

Дорнод аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгдсэн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд Сангийн яаманд нэгтгүүлсэн байна.

Дорнод аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо, холбогдох тохируулгын тайлан мэдээг Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон Сангийн сайдын баталсан заавар, журмын хүрээнд, хуульд заасан хугацаанд боловсруулан тайлагнаж ажиллаж байна.

2.3. Аймгийн төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна.

2.3.1. Аймгийн төрийн сангаас сумдын төрийн санд дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайланг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийг батлуулж, тогтмол хэрэгжүүлж, тайланг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан боловч удирдамжийг хууль, журамд заасан эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д “.....аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.5-д “Аймаг, нийслэлийн төрийн сан энэ журмын 3.9.3.1-д заасан дотоод хяналт хийх төлөвлөгөөг Засаг даргаар,

удирдамжийг санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар тус тус батлуулан мөрдөж ажиллана”, Сангийн сайдын “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар шинэчлэн батлах тухай” 254-р тушаалын хавсралтаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 4.2-т “Төлөвлөгөөт дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийг тухайн оны эхний улиралд багтаан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.4, 3.9.5-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулна” гэж тус тус заасны дагуу Дорнод аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтын төлөвлөгөөг дараах байдлаар батлуулсан байна. Үүнд:

- Дотоод хяналтын 2023 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 03-ны А/78 дугаар захирамж,
- Дотоод хяналтын 2024 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 25-ны А/125 дугаар захирамж,
- Дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны А/71 дүгээр захирамжаар тус тус батлуулсан байна.

Тус төлөвлөгөөний дагуу дотоод хяналтаар явах ажлын удирдамжийг 2023-2025 онд аймгийн Засаг даргын тамгын газрын даргаар батлуулсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу жил бүр 14 сумдад хийж гүйцэтгэсэн байна. Дотоод хяналтын 2023, 2024, 2025 оны тайланг албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж ажилласан байна.

Дотоод хяналтаар 2025 онд Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Булган, Дашбалбар, Матад, Халхгол, Хөлөнбуйр, Чулуунхороот зэрэг 9 сумдад зөвлөмж өгч, тус сумдаас зөвлөмжийн биелэлтийг аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.


Дээр дурдсан Дотоод хяналтаар явах ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын тамгын газрын даргаар батлуулсан нь “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.5-д заасан “удирдамжийг санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар батлуулна” гэсэн шаардлагад нийцээгүй байна. Журмыг хэрэгжүүлж ажиллах **зөвлөмж өгөв**.

2.3.2 Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж ажилласан байна.

2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.8-д дараах заалтыг тусгасан.

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх зааварт заасны дагуу үнэлж, удирдлагадаа танилцуулна.


Дүрслэл 7. Зөрчлийн чиг хандлага



Дотоод хяналтын 2023, 2024, 2025 оны тайлангуудад шинжилгээ хийж үзэхэд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг холбогдох заавар, журмын дагуу үнэлэн ажилласан бөгөөд өдөр тутмын дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд тогтмол хэрэгжүүлж, хяналт шалгалтын үр дүнг тайлагнан удирдлагад танилцуулж, илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласны үр дүнд эрсдэлийн нийт оноо буурсан боловч зөрчлийн нийт үзэгдэл буурахгүй байна.

- Системд нэвтрэх эрхийн гарын үсгийн баталгааны маягтын бүрдэл дутуу /14 суманд давтан/
- Шилэн дансны хуулийн зөрчил /2 дахин өссөн/
- Анхан шатны баримтын зөрчил /Буураагүй/
- Нягтлан бодогч томилгооны зөрчил /Нэмэгдсэн/
- Архивын ажил /Сайжирсан/
- Хүний нөөцийн дутагдал /Сайжирсан ч хэвээр/
- Системийн эрх шилжүүлэлтийн зөрчил /Халхгол төрийн сан/

Дүрслэл 8. Зөрчлийн ангилал



Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 “Төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж

төлбөрийн амлалтыг бүртгэх,” заалтыг орон нутагт хэрэгжүүлдэггүй бөгөөд уг заалт нь бодит байдал дээр орон нутгийн түвшинд хэрэгжих боломжгүй байна.

ҮАГ-ын нэгдсэн тайланд: Хуулийн уг заалтыг хасах санал хүргүүлэв.

2.3.3 Дорнод аймгийн Төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд төрийн аудит болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

Дорнод аймгийн Төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд Төрийн аудит болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн”-д 2018 онд аудит хийгдсэн байна. Аудитаар нийт 760.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 696.0 сая төгрөгийн 1 албан шаардлага болон 6 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал, Гурванзагал, Дашбалбар, Чойбалсан, Цагаан-Овоо сумын төсвийн байгууллагуудын албан хаагчдын цалинтай холбоотой тогтоогдсон төлбөрийн актын 3.7 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна. Зарим төсвийн байгууллагууд төрийн сангийн төлбөр тооцоог хийхдээ 1, 2 дугаар гарын үсгийн аль нэг нь зурагдаагүй, байгууллагын тамга тэмдэг дарагдаагүй, баталгаажуулаагүй төлбөрийн хүсэлтээр төрийн санд гүйлгээ хийсэн тухай зөрчилд өгсөн албан шаардлага, төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn
Цахим хуудас: Dornod.gov.mn

2026.05.28 № 01/1343

танай _____-ны № _____-г

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайланд 1 саналд хариу тайлбар хүргүүлээ. Бусад зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Хавсралт: 3 хуудастай

ЗАСАГ ДАРГА  Ш.ЁЛ



2126070290

Аймгийн Засаг даргын 2026 оны 05
сарын 28-ны өдрийн 013.43
албан
бичгийн хавсралт

Тайлангийн дүгнэлт хэсгийн 2.2.2 -т “төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болж буцсан 391.3 сая төгрөгийн 77 гүйлгээ байна” гэсэн заалт дээр дараах тайлбарыг хүргүүлж байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системд 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 6 төсвийн байгууллагын 38 ширхэг 52.3 сая төгрөгийн гүйлгээ нь системийн алдаанаас болж буцсан болно.

Буцсан гүйлгээний жагсаалтыг цахимаар хүргүүлэв.

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналыг аудитын тайланд дараах байдлаар тусгасан. Үүнд: Санал 1-ийг аудитын тайлангийн 2.2.2-т тусгасан.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1.2. Орон нутгийн холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зарим тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцээгүй байна.

1.2.1 Аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тоо ялгаатай байгаа нь улсын хэмжээнд мөрдөх нэгдсэн бүтэц, орон тооны жишиг норматив баталж гаргаагүйтэй холбоотой байна.

1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй ч, албан тушаалын тодорхойлолт нь орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавартай бүрэн нийцэхгүй байна.

1.2.3. Төсвийн төлөвлөлтийн Fiscal программ нь төсвийг үр дүнтэй төлөвлөх хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

2.1.1. Төрийн сан нь төсвийн байгууллагын төсвийн санхүүжилтийн эрхийг батлагдсан хуваарийн дагуу нээхдээ төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан холбогдох баримт шийдвэргүй шууд нээсэн байна.

2.1.2. Улсын 2025 оны төсвийн орлого тасарсантай холбоотой төсвийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Сангийн яамнаас зардлуудыг хязгаарласны улмаас 4,107.2 сая төгрөгийн санхүүжилт Дорнод аймагт дутуу олгогдсон байна.

2.2.2. Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу гүйлгээнүүд нь нийт буцсан гүйлгээний 85.5 хувийг эзэлж байгаа бол Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болж буцсан 339.0 сая төгрөгийн 39 гүйлгээ байна.

2.2.3. Тайлант онуудад 1,511.1 сая төгрөгийн гүйлгээг залруулснаас 38.9 сая төгрөгийн 2 гүйлгээнд холбогдох байгууллагын шийдвэр, төлбөр хийх хүсэлт зэргийг хавсаргаагүй байна.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнасан байна.

2.3.1. Аймгийн төрийн сангаас сумдын төрийн санд дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайланг удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

2.3.2 Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж ажилласан байна.

2.3.3 Дорнод аймгийн Төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд төрийн аудит болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

Аудитаар нийт 377.9 сая төгрөгийн зөрчил илэрч 8 зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 7 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

Сангийн яаманд

1. Сумын санхүүгийн албаны дарга ОНХС-гийн гүйлгээн дээр гарын үсэг зурахгүй байх талаар холбогдох журамд тусгах.
2. Сумын төрийн сангийн дотоод хяналтыг хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.
3. Аймгуудын хүн амын тоо, засаг захиргааны нэгж (сум)-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл болон төсвийн цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр "Аймгуудын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тооны жишиг норматив"-ыг шинээр боловсруулан баталж, улсын хэмжээнд нэгдсэн байдлаар мөрдүүлэх.
4. Payrol цалингийн системд сайжруулалт хийж эрх бүхий байгууллагын шийдвэрийг оруулан тухайн дүнгээр үндсэн цалинг татдаг болгох,
5. Fiscal, Fiscal.b8 программуудад шинэчлэл хийж төсвийн байгууллагууд төсвийн мэдээллээ оруулдаг болох, төрийн сангаас нэгтгэж татдаг болгож сайжруулах.
6. орон нутгийн төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно гэсэн заалтыг өөрчлөх.
7. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 “Төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;” заалтыг орон нутагт хэрэгжүүлдэггүй бөгөөд уг заалт нь бодит байдал дээр орон нутгийн түвшинд хэрэгжих боломжгүй тул хасах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёлд:

1. ОНХС-гийн зарцуулах эрхийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж ...;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлбөрийн хүсэлт гүйлгээн дээр аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор 2-р гарын үсэг зуруулах.

3. Сумдын интернэтийн хурд, тогтвортой байдлыг үнэлж, шаардлагатай сумдад сүлжээний хүчин чадал, нөөц холболтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

Дорнод аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга В.Цэнгэлмаад:

1. Аймгийн төрийн сангийн мэргэжилтнүүдийн АТТ-г жишиг загварт бүрэн нийцүүлэх, Халхгол, Чулуунхороот, Дашбалбар, Чойбалсан сумдыг ТАЗ-ийн тогтоолд нийцүүлж АТТ-ыг батлуулах ажлыг зохион байгуулах.

2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6.3.-ийн дагуу орон нутгийн төсвийн байгууллагаас хүсэлт авч санхүүжилтийг олгон ажиллах.

3. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төлбөр тооцоог ажлын 3 хоногт багтаан гүйлгээг баталж ажиллах.

4. Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу холбогдох байгууллагын шийдвэр, төлбөр хийх хүсэлт зэргийг хавсаргаж гүйлгээг залруулж ажиллах.

5. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.5-д заасан “удирдамжийг санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар батлуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан.

Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/17

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2126010002

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN